



Төв аймгийн Засаг даргын дэргэдэх
Статистикийн хэлтэс



ТӨВ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2020/4





Хүн ам, улсын бүртгэл, соёл

Хүн ам

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2020 оны эхний 4 сард төрсөн хүүхэд 640; нас барсан хүн 153; бусад аймаг хотоос шилжин ирсэн 603 хүн бүртгэгдлээ. Төрсөн хүүхдийн 93.8, нас барсан хүний 131.4 хувь нь хүн ам, өрхийн мэдээллийн сан(ХАӨМС)-д оруулжээ.

Улсын төсөвт 2020 оны эхний 4 сард 27.4 сая ₮ төвлөрүүлсэн нь 2019 оны мөн үеэс 9.0 хувь буюу 2.3 сая ₮-өөр өслөө. Орон нутгийн төсөвт 2020 оны эхний 4 сард 8.3 сая ₮ төвлөрүүлсэн нь 2019 оны мөн үеэс 8.7 хувь буюу 793.4 мянган ₮-өөр буурлаа.

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2020 оны эхний 4 сард нийт 5107 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 208; төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны баталгаажуулалт 63; төрөөс худалдаж авсан газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 4; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 1680; бэлэглэлийн гэрээ 96; худалдах, худалдан авах гэрээ 350; өв залгамжлал 43; барьцааны гэрээ 1134; бусад бүртгэл 1529-ийг тус бүр бүртгүүллээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2020 оны эхний 4 сард нийт 47 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснийг хариуцлагын хэлбэрээр ангилбал: хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 31; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 2; гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага 2; хоршоо 1; төсөвт 9; төрийн өмчит улсын үйлдвэрийн газар 1; хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл 1 бүртгүүллээ.

Хуулийн этгээдийн бүртгэлээр 2020 оны эхний 4 сард 89 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 31; гишүүн нэмэгдсэн хасагдсан 1; дахин гэрчилгээ 8; удирдлага өөрчлөгдсөн 16; үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 16; дүрмийн сан нэмэгдсэн хасагдсан 8; хаяг өөрчлөгдсөн 2; нэр хэлбэр өөрчлөгдсөн 3; татан буугдсан 4 тус бүр бүртгүүллээ.



Нийгмийн даатгал, нийгмийн халамж

Нийгмийн даатгал


Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2020 оны эхний 4-р сард НДШ-ийн орлого 7.7 тэрбум.₮ болж төлөвлөгөө 126.4 хувь биелэлээ. Төлөвлөгөөг Жаргалант, Баянчандмань сум 0.2-4.7 хувиар тасалдуулж, бусад 25 сум 2.2-72.4 хувиар давуулан биелүүллээ. Сайн дурын НДШ-ийн орлого 714.4 сая.₮ болж төлөвлөгөө 7.4 хувиар тасалдав. Төлөвлөгөөг Батсүмбэр, Жаргалант, Эрдэнэ, Баянжаргалан, Баяндэлгэр, Алтанбулаг сум 1.9-13.6 хувиар давуулан биелүүлж, бусад 21 сум 2.3-32.3 хувиар тасалдуулав.

Тэтгэвэр, тэтгэмжид 21.6 тэрбум.₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 81.3 хувийг өндөр настны, 10.3 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.4 хувийг тэжээгчээ алдсаны, 5.0 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 381609.6 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 33.3 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 24.8%; тэтгэмжийн даатгалын сангийн 68.8%; эрүүл мэндийн даатгалын сангийн 98.9%; үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 114.6%; ажилгүйдлийн даатгалын сангийн 40.8%-ийг тус тус бүрдүүлжээ.

Нийгмийн даатгалын сангуудын орлого зарлагын харьцаа
(төрлөөр)



2020 оны 4-р сарын эцэст нийгмийн даатгалын сангийн авлага 983.8 сая.₮, өглөг 173.3 сая.₮ боллоо.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2020 оны эхний 4 сарын нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 62926 хүнд олгож, 7.5 тэрбум ₮-ийг зарцуулж 2019 оны мөн үеэс хүний тоо 20.9 хувь 16669 хүнээр буурч, зарцуулсан мөнгөний хэмжээ 6.7 хувь 469.7 сая ₮-өөр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 184900₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 43.2 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 17.5 хувийг халамжийн тэтгэвэр; 8.0 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 5.6 хувийг насны хишгийн зардал; 2.9 хувийг цалинтай ээж хөтөлбөрийн зардал; 1.5 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж; 0.5 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 0.5 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж; 0.4 нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид тус бүр зарцуулжээ.





ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын тасгийн мэдээгээр эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 2020 оны эхний 4 сард 1.0 тэрбум.₮ болж, эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж, үйлчилгээний зардалд 1.5 тэрбум.₮ зарцуулав.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага*, төрлөөр, эхний 4 сард, сая.₮

Үзүүлэлт	2020 I-IV
Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого	1,044.9
Даатгуулагчийн өөрөө хариуцан төлсөн шимтгэл	129.9
Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	33.9
Малчин	87.0
Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч	8.9
Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн	228.9
Төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн	686.2
Эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж үйлчилгээний зардал	1,498.2
Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардал	991.5
Сувиллын тусламж үйлчилгээний зардал	287.9
Эмийн үнийн хөнгөлөлтийн зардал	218.8

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 4 сард эрүүл мэндийн даатгалд давхардсан тоогоор 74.1 мянган даатгуулагч хамрагдсаны 15.4 хувь нь шимтгэлийг ажил олгогч, даатгуулагч хариуцан төлсөн иргэд, 5.3 хувь нь шимтгэлийг өөрөө хариуцан төлсөн иргэд, 79.3 хувь нь шимтгэлийг улсын төсвөөс хариуцсан иргэд байна.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдагчид 4 дүгээр сарын байдлаар, хүнээр

Үзүүлэлт	2020 IV
Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчид	74149
Шимтгэлийг ажил олгогч хариуцан төлсөн иргэд	11386
Төсөвт байгууллагын ажилтан	7502
Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан	3884
Шимтгэлийг өөрөө хариуцан төлөх иргэд	3946
Малчин	1923
Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	1805
Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч	218
Бусад даатгуулагч	
Шимтгэлийг улсын төсвөөс хариуцсан иргэд	58817

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлдэг эмийн борлуулт 2020 оны эхний 4 сард 60.4 сая.₮ болов.

Зүрх судасны эмийн борлуулалт 2020 оны эхний 4 сард 31.8 сая.₮ болж нийт борлуулалтын 52.5 хувийг, халдварын эсрэг эм бэлдмэл 13.5 сая.₮ болж нийт борлуулалтын 22.4 хувийг, ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эмийн борлуулалт 4.7 сая.₮ болж нийт борлуулалтын 7.7 хувийг, сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм 5.8 хувийг эзэлжээ.



Эрүүл мэнд

2020 оны эхний 4 сард 4999 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.3 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2020 оны эхний 4 сард 350 хүүхэд мэндэлсэн нь 2019 оны мөн үеэс 6 хүүхдээр өслөө.

Он гарсаар 1 хүртэлх насандаа нас барсан хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 1 хүүхдээр өслөө.



Эмнэлгийн мэдээгээр 2020 оны эхний 4 сард 125 хүн нас барсан нь 2019 оны мөн үеэс 17.2 хувиар буурлаа. Нас барсан хүний 13.6 хувь буюу 17 нь эмнэлэгт нас баржээ.


Нас баралтыг шалтгаанаар аваад үзвэл хорт хавдарын нас баралт хамгийн өндөр 31.2 хувь, гадны шалтгаан 15.2 хувийг эзлэв.

2020 оны эхний 4 сард халдварт өвчнөөр 160 хүн өвчилсөн нь 2019 оны мөн үеэс 17.9 хувь буюу 35 хүнээр буурлаа. Халдварт өвчлөлийг өмнөх онтой харьцуулбал тэмбүү 1.2 дахин, цусан суулга 66.7, заг хүйтэн 66.7 хувь тус тус өсчээ. 10000 хүнд ногдох халдварт өвчлөл аймгийн дундаж 17 байгаа бол: Зуунмод 57, Баян 28, Сүмбэр 27, Цээл 24, Архуст 23, ногдлоо.

10000 хүнд ноогдох халдварт өвчний тоог газрын зургаар харуулвал.

	Интервал-хүнээр	Сумын тоо
	2-6	9
	7-14	6
	15-28	6
	29-57	1
	0	5

 Сум хилийн зааг



АЖИЛГҮЙЧҮҮД

2020 оны 4 дүгээр сард ХХҮГ-ын хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 324 болж, 2019 оны мөн үеэс 64 хүнээр буурч, өмнөх сараас 32 хүнээр өсөв.

Ажилгүйчүүдийн 58.0 хувь буюу 188 нь эмэгтэйчүүд юм. 2020 оны эхнээс 204 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 89 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 62.9 хувь буюу 41 нь эмэгтэйчүүд байв. Ажилгүйчүүдийн бүртгэлээс оны эхнээс 468 иргэн хасагдлаа.

Аймгийн бүртгэлтэй ажилгүйчүүдийн 19.4 хувь нь Зуунмод суманд; 19.4 хувь нь Борнуур суманд; 15.1 хувь нь Угтаалцайдам суманд; 7.7 хувь нь Цээл суманд; 6.5 хувь нь Баян суманд бүртгэгджээ.

Тайлант сард бүртгүүлсэн 113 ажилгүй иргэний 28.3 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 22.1 хувь нь шилжин суурьшсан; 7.1 хувь нь орон тооны цомхтголд орсон; 1.8 хувь нь цэргээс халагдсан; 1.8 хувь нь гүйцэтгэж буй албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 0.9 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 0.9 хувь нь тэтгэвэрт; 35.4 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.



Ажилгүйчүүдийг боловсролын түвшингөөр хуваавал 15.7% нь дээд; 5.2% нь тусгай дунд; 6.8% нь мэргэжлийн анхан шатны; 61.7% нь бүрэн дунд; 7.7% нь бүрэн бус дунд; 2.5% нь бага; 0.3% нь боловсролгүй иргэд юм.

Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд дунджаар 55 ажилгүйчүүд ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 8 хүнээр бага ногдов. Аймгийн дундажтай сумдын дунджийг харьцуулбал Баянчандмань, Зуунмод, Цээл, Баянхангай, Баян, Борнуур, Угтаал сумдад аймгийн дунджаас олон ажилгүйчүүд (60-299 хүн) ногдов.


Тайлант сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс ажилд зуучлуулсан 18 иргэний 55.6 хувь нь бүрэн дунд; 22.2 хувь нь дээд; 11.1 хувь нь мэргэжлийн анхан шатны; 5.6 хувь нь тусгай дунд; 5.6 хувь нь бүрэн бус дунд боловсролтой иргэд байв.

2020 оны эхнээс байнгын ажлын шинэ байранд 123 иргэн ажилд оржээ. Эдийн засгийн салбарын ангиллаар ангилбал 22.8 хувь нь Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээний; 17.1 хувь нь Боловсруулах үйлдвэрлэлийн; 16.3 хувь нь Боловсролын; 13.0 хувь нь Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал; 11.4 хувь нь ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын; 6.5 хувь нь барилгын; 4.9 хувь нь Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний; 2.4 хувь нь Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны; 1.6 хувь нь Тээвэр ба агуулахын үйл ажиллагааны; 1.6 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны; 1.6 хувь нь Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны; 0.8 хувь нь урлаг, үзвэр, тоглоом, наадмын үйл ажиллагааны салбаруудад тус тус ажилд орлоо. Нийт байнгын ажлын шинэ байрыг бий болгосон хөрөнгийн эх үүсвэрээр ангилбал 47.2 хувийг улсын төсвийн хөрөнгөөр, 35.8 хувийг хувийн хөрөнгөөр, 14.6 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр, 0.8 хувийг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр, 1.6 хувийг бусад хөрөнгөөр бий болгов.

Улирлын шинэ ажлын байранд 7, түр ажлын шинэ байранд 332 хүн /дийлэнх нь оготно устгалын ажил/ тус тус ажилд оров.




Ажилгүйчүүд-боловсролын түвшингээр



10000 ХҮН АМД НОГДОХ АЖИЛГҮЙЧҮҮДИЙГ СУМДААР ҮЗҮҮЛБЭЛ:

	Интервал-хүнээр	Сумын тоо
	0-9	7
	10-27	7
	28-60	8
	61-299	5



Байгаль орчин

2020 ОНЫ ТАВДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Төв аймгийн нутгаар. Энэ сарын агаарын дундаж температур зүүн хойд хэсгээр 4-8 градус дулаан, бусад нутгаар 8-14 градус дулаан байдаг. Нийт нутгаар ОЖД-аас дулаан байх төлөвтэй.

Map of Mongolia showing the distribution of average annual precipitation by province. The map is color-coded: light blue for 6-8 degrees, yellow for 9-11 degrees, and orange for 12-14 degrees. Major cities are marked with a cross and labeled in Cyrillic. A legend in the bottom right corner explains the color coding.

Color	Range (degrees)
Light Blue	6-8
Yellow	9-11
Orange	12-14

Хур тунадас: 5 дугаар сард олон жилийн дунджаар нутгийн хойд хэсгээр 20.0-25.0 мм, бусад нутгаар 15.0-19.0 мм орчим хур тунадас ордог. Энэ сард ОЖД–аас бага. Тавдугаар сард агаарын дундаж температур сүүлийн жилүүдэд, ялангуяа 2017-2018 онуудад хамгийн дулаан буюу ОЖД – аас 2⁰C-аар дулаарч өдөртөө төв, зүүн, говийн аймгуудын нутгаар 31-36⁰C хүрч халж байв. Харин 2014-2016, 2019 онуудад ОЖД – аас 0.5-1.0 ⁰C-аар хүйтэн байсан.

[illegible]

5 дугаар сард ихэнх нутгаар хур тунадас олон жилийн дунджаас бага орох боловч үе үе хүчтэй салхи шуургатай, өдөр шөнийн температурын хэлбэлзэл ихтэй, шөнөдөө хүйтэн байх тул цочир хүйтэрхийг анхааруулж байна.


Төрийн хяналт

Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2020 оны эхний 4 сарын мэдээгээр нийт 118 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлэв. Тохирлын баталгаажуулалт нийт 138 хийснээс тохирлын гэрчилгээ 128, дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт 10; хэмжих хэрэгслийн баталгаажуулалт нийт 1346 хийснээс массын хэмжүүр 201, үүнээс жин 177, туухай 23, автомашины жин 1; эзлэхүүн зарцуулалтын хэмжүүр 102, үүнээс түгээгүүрийн хошуу 80; мерник 8; сүмбэн метр 12; усны тоолуур 2; нэг фазын тоолуур 1043-ыг тус бүр баталгаажуулсан байна.

Санхүүгийн хяналт, шалгалт

Санхүүгийн хяналт, аудитын алба 2020 оны эхний 4 сард 138 нэгж байгууллагад хяналт, шалгалт хийж 481.0 сая ₮-ийн зөрчил, төлбөр илрүүлж төлүүлбэл зохих 114.7 сая ₮-ийн акт тавив. Төлбөрийн барагдуулалт 6.7 сая ₮ болж 5.9 хувийн биелэлттэй гарлаа.




Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2020 оны эхний 4 сард аймгийн хэмжээнд 299 гэмт хэрэг бүртгэгдэж 182 хүн холбогдож, иргэдийн өмчид 1.4 тэрбум ₮-ийн хохирол учирлаа.

Гарсан гэмт хэргийн 41.1 хувь нь хулгай, 19.5 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний эсрэг хэрэг, 8.4 хувь нь замын осол, 2.4 хувь нь хүний амь, 28.6 хувь нь бусад хэрэг тус бүр эзлэв. Баянцогт, Сүмбэр, Сэргэлэн, Аргалант, Баянхангай, Баянцагаан, Лүн, Өндөрширээт, Эрдэнэ, Эрдэнэсант, Зуунмод, Баян сумдад 10000 хүнд 233-50 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (48)-аас харьцангуй их байна.


Гэмт хэргийн тоо 2019 оны мөн үеэс 8 хэргээр өслөө.

Зуунмод суманд 5 эмэгтэй, 111 эрэгтэй нийт 116 хүн эрүүлжүүлэгдсэн байна.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2020 оны эхний 4 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 491 гүйцэтгэх хуудсанд нийт 5.3 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс биелүүлбэл зохих 475 гүйцэтгэх хуудасны 4.7 тэрбум ₮-өөс 152 хуудасны 609.7 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 32.0 үнийн дүнгээр 12.7 хувь болж 2019 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 1.2 нэгжээр өсч, үнийн дүнгийн биелэлт 4.6 нэгжээр буурлаа.






ТӨСӨВ, МӨНГӨ


Төсвийн орлого 2020 оны эхний 4 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 7.8 тэрбум ₮, зарлага 27.3 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 105.1 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас; Хувь хүний орлогын албан татвар; Галт зэвсгийн албан татвар; Тусгай зориулалтын орлого; Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр; ус, рашаан ашигласны төлбөр; орон нутгийн газрын төлбөр, хөрөнгө борлуулсны орлого биелэгдсэнгүй.

Аймгийн төсвийн орлого 2019 оны мөн үеэс 15.1 хувь буюу 1.0 тэрбум ₮-өөр өслөө. Аймгийн төсвийн орлогын 89.1 хувийг татварын, 10.4 хувийг татварын бус орлого, 0.03 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2019 оны мөн үеэс татварын орлого 1.9 нэгжээр өсч; татварын бус орлого 1.5 нэгжээр, хөрөнгө борлуулсны орлого 0.4 нэгжээр тус бүр буурлаа.

Аймгийн нийт 3 шатны орлого 9.4 тэрбум ₮ болж аймгийнх 6.5 тэрбум ₮ буюу 69.3 хувь; сумынх 1.3 тэрбум ₮ буюу 13.7 хувь; улсынх 1.6 тэрбум ₮ буюу 17.0 хувийг тус бүр бүрдүүлжээ.



2019 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 1.3 дахин буюу 377.5 сая ₮-өөр буурч 299.4 сая ₮ болж, авлага 48.3 хувь буюу 54.3 сая ₮-өөр өсч 166.7 сая ₮ боллоо.




Орон нутгийн төсвийн орлого 7.0 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 108.3 хувь биелэв. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 1.3 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 87.9 хувь биелэв. Жаргалант, Баян, Сэргэлэн, Эрдэнэ, Баянжаргалан, Эрдэнэсант, Зуунмод, Бүрэн, Баянцагаан, Угтаал, Дэлгэрхаан сумд 74.3-5.2 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлого 6.5 тэрбум ₮ болж төлөвлөгөө 109.3 хувь биелж Баян, Баянчандмань, Баянжаргалан, Архуст сумд 71.1-34.1 хувиар тасалдууллаа.


Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн банкны салбаруудын дүнгээр 2020 оны эхний 4 сард кассын орлого 129.7 тэрбум ₮, кассын зарлага 129.6 тэрбум ₮ болж, гүйлгээнд 103.3 тэрбум ₮ байна.

ХААН, Хас, Төрийн банкны салбарын нийт зээлийн багц зээлдэгчийн тоо 34967, зээлийн багцын дүн 176.1 тэрбум ₮; 2020 онд зээл авсан зээлдэгчийн тоо 23187, олгосон зээлийн дүн 60.3 тэрбум ₮ боллоо.




Иргэдийн хувийн хадгаламжинд 4 сарын 30-ний байдлаар хугацаатай хадгаламж 70.3 тэрбум ₮, хугацаагүй хадгаламж 19.4 тэрбум ₮ байна.



4 сарын 30-ны байдлаар иргэдийн харилцах дансны үлдэгдэл 127198 иргэний 15.5 тэрбум ₮, 1373 байгууллагын 9.8 тэрбум ₮ боллоо.



ХААН, Төрийн, Хас банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.3-0.6 хувь, хугацаатай доод хүү 0.1-0.7 хувь, хугацаагүй дээд хүү 0.6 хувь, хугацаагүй доод хүү 0.1-0.5 хувьтай байна.





ҮНЭ, ТАРИФ

а. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2020 оны 4 дүгээр сард суурь он буюу 2015 оны 12 дугаар сараас 22.8 хувь, өмнөх оны мөн үеэс 3.6 хувь, оны эхнээс 1.1 хувиар тус тус өсч өмнөх сараас 1.3 хувиар буурав.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар өсөхөд боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 11.6 хувь; хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ дүнгээрээ 8.2 хувь; хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 6.3 хувь; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ дүнгээрээ 4.1 хувь; бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.9 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Мөн эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.6 хувь; гэр ахуйн тавилга, барааны бүлгийн үнэ дүнгээрээ 2.3 хувь; амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.2 хувь; орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ дүнгээрээ 1.5 хувь; зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ дүнгээрээ 0.3 хувиар тус тус өсч, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 5.6 хувиар бууран холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ хэвээр хадгалагдав.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 4 дүгээр сард өмнөх сараас 1.3 хувиар буурахад тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 5.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувь; гэр ахуйн тавилга, барааны бүлгийн үнэ дүнгээрээ 1.6 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ. Тайлант хугацаанд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ дүнгээрээ 0.7 хувь; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувиар тус тус өсөв. Боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ; зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ; холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ тогтвортой байв.


2020 оны 4 дүгээр сард өмнөх сараас хэрэглээний сагсны 238 нэрийн бараа, үйлчилгээний 17.2 хувийнх нь үнэ өсөж, 12.6 хувийнх нь үнэ буурч, 65.5 хувийнх нь үнэ тогтвортой байв.



2020-04/2015-12



2020-04/2019-04



2020-04/2019-12



2020-04/2020-03



б. Хөдөөд 2020 оны 4 дүгээр сард бараа үйлчилгээний үнэ тариф суурь он буюу 2015 оны 12 сартай харьцуулахад 21.3%, өмнөх оны мөн үе буюу 2019 оны 4 дүгээр сартай харьцуулахад 2.1%-аар тус тус өсч, өмнөх сартай харьцуулахад 1.2%-аар буурав.




Хөдөө аж ахуй

Төл бойжилт


2020 оны 5 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 68.2 хувь 1570.7 мянган хээлтэгч мал төллөж, 1578.2 мянган төл гарсны 98.7 хувь 1557.3 мянган төл бойжиж байгаа нь урьд оны мөн үеэс төллөсөн хээлтэгч 17.1 хувь буюу 229.6 мянгаар; бойжиж буй төл 16.7 хувь буюу 222.3 мянган төлөөр тус бүр өсч; 2011-2019 оны мөн үеүдийн дунджаас төллөсөн хээлтэгч 41.1 хувь 457.5 мянгаар, бойжиж буй төл 41.6 хувь 457.5 мянгаар тус бүр өслөө.

Оны эхний төллөх насны ингэний 26.1; гүүний 21.7; үнээний 36.1; эм хонины 74.7; эм ямааны 71.3 хувь нь тус бүр төллөв.

Төллөсөн хээлтэгч мал (эхний 4 сараар)





Төл бойжилтын хувь (эхний 4 сараар)




	Интервал-төлөөр	Сумын тоо
	91.4-99.0	8
	99.1-99.5	7
	99.6-99.8	8
	99.9-100.0	4



Сумын хилийн зааг




Гарсан төлийн 1.3 хувь 20839 болох толгой төл хорогдсон нь урьд оны мөн үеэс 20.7 хувь буюу 3576 төлөөр өсч; 2011-2019 оны мөн үеүдийн дунджаас 5.9 хувь буюу 1318 төлөөр буурлаа. Гарсан ботгоны 0.8, унаганы 1.0, тугалын 1.0, хурганы 1.0, ишигний 1.9 хувь нь тус бүр хорогдов. Хамгийн их хорогдолтой 5 сум Эрдэнэсант, Баянжаргалан, Өндөрширээт, Алтанбулаг, Баянчандмань сумд гарсан төлийнхөө 8.6-0.7 хувь буюу 6769-744 төл хорогдуулсан нь аймгийн бүх төлийн хорогдлын 75.3 хувийг (бүгд 15701 төл) эзлэв.




Том малын зүй бус хорогдол

2020 оны 5 сарын 1-ний байдлаар оны эхний малын 0.2 хувь буюу 17792 том мал зүй бусаар хорогдсон нь 2019 оны мөн үеэс 44.2 хувь буюу 7871 толгойгоор өсч; 2011-2019 оны мөн үеүдийн дунджаас 1.0 дахин буюу 17966 толгойгоор буурлаа. Хамгийн их хорогдолтой 5 сум Баянжаргалан, Бүрэн, Эрдэнэсант, Өндөрширээт, Лүн сумд оны эхний малынхаа 2.4-0.3 хувь буюу 5015-837 том мал зүй бусаар хорогдуулсан нь аймгийн бүх хорогдлын 66.4 хувь (бүгд 11821) эзлэв.


Оны эхний тэмээний 0.2; адууны 0.3; үхрийн 0.2; хонины 0.3; ямааны 0.3 хувь нь тус бүр хорогдов. Бүх зүй бусаар хорогдсон малын 22.4 хувь нь өвчнөөр, 56.3 хувь нь хээлтэгч мал эзлэв.




Том малын хорогдолын оны эхний малд эзлэх хувь-
(эхний 4 сард)



Хорогдсон том мал (эхний 4 сард)





АЖ ҮЙЛДВЭР

Өмчийн бүх төрлийн аж үйлдвэрийн газрууд 2020 оны эхний 4 сард (2010 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 8.7 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2019 оны мөн үеэс 11.0 хувь буюу 0.8 тэрбум ₮-өөр өслөө.

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөн нь ашигт малтмал олборлолт, өмнөх оноос 18.0 хувь буюу 0.5 тэрбум ₮-өөр өссөн нь нөлөөлөв.

Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Жаргалант, Зуунмод, Баянчандмань, Баянцогт сумд 41.2-2.9 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 92.2) хувийг эзлэв.

2020 онд нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 38.7, боловсруулах үйлдвэрлэл 19.2 ашигт малтмал олборлолт 42.1 хувийг тус тус эзлэв.



Энэ онд аж үйлдвэрийн гол нэр төрлийн 27 бүтээгдэхүүнээс 8 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өнгөрсөн оноос нэмэгдлээ. Нэр төрлөөр нь үзвэл: алт, түгээсэн цэвэр ус, монгол гутал, эсгий гутал, зүсмэл материал, бланк, шингэн сүү зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсч, сувагжуулалт, төмрийн хүдэр, талх, савхин гутал, ундаа рашаан, куртка, өмд, цамц желет, плъто, хөвөнтэй бээлий, бяслаг, арвайн гурил, ажлын хувцас, гэрийн модон эдлэл, монгол дээл, төмөр эдлэл, хүснэгт маягт, шохойн чулуу, нарийн боов, хэрчсэн гурил, спорт хослол, угаасан ноос, эмэгтэй хослол, жонш, ногооны консерв, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл буурав.

Аж үйлдвэрийн салбарын дүнгээр 2020 оны эхний 4 сарын үнээр 13.4 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн борлуулсан нь 2019 оны мөн үеэс 1.0 хувь буюу буюу 0.1 тэрбум ₮-аар өслөө.


Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Жаргалант, Зуунмод, Баянчандмань, Баянцогт сумд 41.2-2.9 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 92.2) хувийг эзлэв.

2020 онд нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 38.7, боловсруулах үйлдвэрлэл 19.2 ашигт малтмал олборлолт 42.1 хувийг тус тус эзлэв.



АУ-ийн бүтээгдэхүүний борлуулалтыг газрын зургаар харуулбал

	Интервал- сая төг	Сумын тоо
	1.8-8.1	7
	8.2-27.8	7
	27.9-137.3	7
	137.4-5520.7	6


Аймаг, сумын хилийн зааг



Аж үйлдвэрийн салбарт 2020 оны эхний 4 сард нийт 1209 хүн ажиллаж бүтээмж 7.2 сая ₮ байгаа нь 2019 оны мөн үеэс 11.5 хувиар өсч, 2018 оны мөн үеэс 20.9 хувиар өслөө.




Ахуй үйлчилгээний байгууллагууд 2020 оны эхний 4 сард 758 цэгт 884 хүн ажиллаж 753.9 сая.₮-ийн орлого үйлчилгээний ажил хийж 295.6 сая.₮-ийн зардал гаргаж 47151 хүнд үйлчилжээ. Нийт орлогын 28.1 хувь нь оёдол, 19.6 хувь нь гутал, 6.4 хувь нь модон эдлэл, 14.8 хувь нь тээврийн хэрэгслийн болон ахуйн техникийн засвар, 12.7 хувь нь үсчин гоо засал, гэрэл зураг, 10.6 хувь нь халуун усны, 6.4 хувь нь бусад үйлчилгээний орлого эзлэв.



БАРИЛГА

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагууд 2020 оны эхний 4 сард 1.3 тэрбум ₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2019 оны мөн үетэй харьцуулахад 12.4 хувиар буюу 189.9 сая ₮-өөр буурав.

Нийт барилга угсралт, их засварын ажлын 52.2 хувь нь орон сууцны барилга байгууламжид, 47.8 хувь нь инженерийн барилга байгууламжид ногдож байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал орон сууцны барилгын ажил 52.2 пунктээр, инженерийн барилга байгууламжийн ажил 43.4 пунктээр тус тус өсч орон сууцны бус барилгын ажил 95.6 пунктээр буурав.



Дээрх ажлуудаас гадна орон нутгийн болон улсын төсвийн санхүүжилт, ТББ, иргэдийн санхүүжилтээр манай аймгийн нутаг дэвсгэрт бусад аймаг, хотын харьяат гүйцэтгэгчид 2020 оны эхний 4 сард 2.8 тэрбум.₮-ийн дараах ажлуудыг гүйцэтгэжээ.



Холбоо

Холбоо ашиглалтын орлого 2020 оны эхний 4 сард 52.8 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 15.1 сая ₮ болж, нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.1 хувь буюу 20.6 сая ₮-өөр буурлаа.



Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 44.8 сая ₮ болсон ба нийт орлогын 81.0 хувь нь хүн амд үйлчилсний орлого байна. Нийт орлогын 18.9 хувийг албан бичгийн 7.8 хувийг зорчигдын, 73.3 хувийг бусад орлого бүрдүүллээ.



ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ

Худалдаа үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын үйл ажиллагааны мэдээг ҮСХ-оос өгсөн түүврийн дагуу цуглуулдаг.

Зоогийн газар

Зоогийн газрын үйлчилгээ эрхэлдэг 15 аж ахуйн нэгж 2020 оны 1-р улирлын мэдээний түүвэрт сонгогдсон ба нийт орлого дүнгээр 109.6 сая төгрөг боллоо. Нийт орлогын 87.3 хувь нь хоолны орлогоос бүрджээ. Нийт зардал 107.2 сая төгрөг байгаагийн 33.3 хувийг ажилчдын цалин, НДШ-д зарцуулжээ.

Зочид буудал

Зочид буудлын үйлчилгээ эрхэлдэг 4 аж ахуйн нэгж 2020 оны 1-р улирлын мэдээний хүрээнд сонгогдон үйл ажиллагаа явуулсан. Эдгээр газруудын нийт орлого 106.9 сая төгрөг, нийт зардал 242.8 сая төгрөгт хүрэв. Салбарт ажиллагчдын тоо 17, эмэгтэй 9 хүн байна.

Барьцаалан зээлдүүлэх

2020 оны эхний 1-р улиралд барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлдэг хүрээнд сонгогдсон 4 аж ахуй нэгж байгууллагын орлого 4.0 сая ₮, зардал 4.3 сая ₮ болж 40.6 сая ₮-ийн зээл олгожээ.

Нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээ

2020 оны эхний 1-р улиралд хүрээнд сонгогдсон нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээ үзүүлдэг аж ахуй нэгж байгууллагын орлого 28.1 сая ₮, зардалд 41.6 сая ₮ зарцуулжээ.

Төрийн бус байгууллага

2020 оны эхний 1-р улиралд орлого 72.5 сая ₮, зарлага 120.9 сая ₮ байгаа нь 2019 оны мөн үеэс орлого 5.8 дахин буюу 102.7 сая ₮-өөр, зарлага 6.0 дахин буюу 183.5 сая ₮-өөр тус бүр буурлаа. Хүрээнд сонгогдсон төрийн бус байгууллагын ажилчдын тоо 147

байгаагийн 122 буюу 82.9 хувь нь Зуунмод суманд байна. Хүрээнд сонгогдсон нийт 42 төрийн бус байгууллага байгаагийн 54.7 хувь буюу 23 нь үйл ажиллагаа явуулж байна.

Мэргэжлийн түр сургалт

2020 оны эхний 1-р улиралд түүврээр сонгогдсон мэргэжлийн түр сургалт явуулдаг аж ахуй нэгж байгууллагын орлого 2.2 сая ₮ байгаа нь өмнөх оны мөн үеэс 80.8 хувиар буурч, 1.8 сая ₮ зарцуулж сургалтанд 12 иргэн хамрагджээ.

Аялал жуучлал

2019 оны 1 улиралын байдлаар аялал жуучлалын үйлчилгээ эрхэлдэг 11 аж ахуй нэгж байгууллага түүвэрт хамрагдаж, 9 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа эхлээгүй 2 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж зарлага 6.3 сая ₮ боллоо.

Мал эмнэлэг

2020 оны I улиралын байдлаар мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлдэг 81 аж ахуй түүвэрт сонгогдсоноос 44 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж орлого 37.4 сая ₮, зардал 39.1 сая ₮ болж, нийт 382083 мал үйлчилгээнд хамрагдлаа.

Статистикийн хэлтэс